

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/20/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23-24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН СУМ ДУНДЫН
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА
Б.АТАРБАЯР ТАНАА

2024.02.20 № СЭА-2024/20/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр "Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон "Ахмадын сан"-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах" гэж үүрэг, чиглэл өгсний дагуу дараах ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Жилийн эцэст тээвэр, шатахууны зардлын хэмнэлтийг татан төвлөрүүлэлгүйгээр 15,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч нөөцөлсөн,
- Цалингийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 56,565.9 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130412508 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс нь ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар баталсан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа нь түүнээс хойш нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт орсон нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс нь тайлант онд “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ” зорилго дэвшүүлж, 5 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 81.6 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	114,952,024.68	198,526,071.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,924,483.00	70,320,392.44
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,924,483.00	70,320,392.44
31210	Төгрөг	18,924,483.00	70,320,392.44
31211	Төрийн сангийн харилцах	18,924,483.00	70,320,392.44
35	БАРАА МАТЕРИАЛ	96,027,541.68	128,205,678.68
35100	Түүхий эд материал	48,795,127.77	62,619,921.27
35110	Тусгай зориулалттай материал	48,176,127.77	62,214,921.27
35130	Эм боох материал	619,000.00	405,000.00
35400	Хангамжийн материал	37,035,037.91	56,628,063.41
35410	Бичиг хэргийн материал	9,161,120.00	4,623,980.00
35420	Аж ахуйн материал	16,198,575.00	19,167,975.00
35440	Түлш, шатах тослох материал	7,620,422.91	25,716,893.91
35460	Хүнсний материал	528,012.00	729,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,526,908.00	6,390,214.50
35600	Мал амьтад	10,197,376.00	8,957,694.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,167,412,753.81	1,087,773,710.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,167,412,753.81	1,087,773,710.94
39200	Биет хөрөнгө	1,000,467,753.79	907,738,711.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,231,456.50	760,231,456.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(106,909,063.68)	(140,203,353.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	286,164,000.00	286,164,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(75,488,888.91)	(126,403,222.35)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	187,498,616.48	235,144,136.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,641,173.76)	(146,552,407.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,137,943.89	30,137,943.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,142,041.73)	(24,396,748.03)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	33,616,905.00	33,616,905.00
39300	Биет бус хөрөнгө	166,945,000.02	180,034,999.94
39301	Программ хангамж	1,240,000.00	1,240,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(454,999.98)	(965,000.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	166,160,000.00	179,760,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,282,364,778.49	1,286,299,782.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	416,237.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	416,237.00	-
41300	Өглөг	416,237.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	416,237.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,281,948,541.49	1,286,299,782.06
51	Засгийн газрын хувь оролцоо	1,281,948,541.49	1,286,299,782.06
51100	Засгийн газрын оруулсан капитал	595,746,480.28	609,346,480.28
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	595,746,480.28	609,346,480.28
51200	Хуримтлагдсан үр дүн	90,714,569.56	81,465,810.13
51210	Өмнөх үеийн үр дүн	155,208,356.39	92,330,369.56
51220	Тайлант үеийн үр дүн	(64,493,786.83)	(10,864,559.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,487,491.65	595,487,491.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,282,364,778.49	1,286,299,782.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/
 430,393,332.00
 МЮА007,393,332.00

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,716,634,734.75	2,730,223,322.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,803,184.75	61,391,722.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,803,184.75	61,391,722.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,055,831.00	7,999,402.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,083,350.00	6,296,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,746,313.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,226,168.00	1,702,902.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	24,315,373.75	35,493,720.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,431,980.00	17,898,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,658,831,550.00	2,668,831,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,653,593,300.00	2,666,891,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,653,593,300.00	2,666,891,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,238,250.00	1,939,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,200,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,038,250.00	1,939,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,781,128,521.58	2,741,087,881.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,781,128,521.58	2,741,087,881.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,773,580,101.24	2,447,784,338.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,432,154,719.00	2,102,422,316.51
210101	Үндсэн цалин	719,846,357.22	1,069,219,291.39
210102	Нэмэгдэл	712,308,361.78	999,219,025.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,984,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,301,369.10	39,888,037.05
210201	Тэтгэврийн даатгал	135,692.73	-
210202	Тэтгэмжийн даатгал	15,963.85	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,771.08	-
210204	Ажилгүйдлийн даатгал	3,192.77	-
210205	Эрүүл мэндийн даатгал	30,133,748.67	39,888,037.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,040,940.24	78,115,348.23
210301	Гэрэл, цахилгаан	13,708,777.90	25,364,233.08
210302	Түлш, халаалт	34,563,397.44	43,442,948.15
210303	Цэвэр, бохир ус	8,768,764.90	9,308,167.00
2104	Хангамж, бараа материалын зардал	85,733,618.32	63,237,604.70
210401	Бичиг хэрэг	10,823,900.00	7,592,300.00
210402	Тээвэр, шатахуун	53,619,318.00	42,946,481.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,003,023.32	5,731,359.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	515,000.00	460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,850,745.00	4,415,640.00
210408	Бараа материал акталсны зардал	4,921,632.00	2,091,824.00
2105	Нормативт зардал	6,222,872.00	4,216,772.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	678,800.00	889,000.00
210502	Хоол, хүнс	5,544,072.00	2,868,772.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	459,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,655,640.00	7,754,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	364,900.00	-
210604	Урсгал засвар	12,290,740.00	7,754,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,865,770.00	4,480,100.00
210702	Дотоод албан томилолт	4,865,770.00	4,480,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,239,620.00	6,123,397.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,559,000.00	781,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	811,500.00	586,099.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	323,800.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	251,400.00	159,658.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	293,920.00	299,640.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,365,552.58	141,546,562.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,038,250.00	512,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	138,327,302.58	140,884,562.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,548,420.34	293,303,543.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,444,000.00	288,587,796.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	66,899,514.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	164,318,282.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,444,000.00	57,370,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,104,420.34	4,715,747.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,104,420.34	4,715,680.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	66.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(64,493,786.83)	(10,864,559.43)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(64,493,786.83)	(10,864,559.43)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,689,053,383.00	2,731,694,009.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,221,833.00	62,862,409.44
120	Нийтлэг татварын бус орлого	30,221,833.00	62,862,409.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,221,833.00	62,862,409.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,083,350.00	6,296,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,138,483.00	56,565,909.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,658,831,550.00	2,668,831,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,653,593,300.00	2,666,891,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,653,593,300.00	2,666,891,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,238,250.00	1,939,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,200,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,038,250.00	1,939,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,655,534,600.00	2,669,138,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,655,534,600.00	2,669,138,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,642,008,979.66	2,375,834,756.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,430,762,089.00	2,156,677,300.00
210101	Үндсэн цалин	845,111,157.42	1,350,737,674.82
210102	Нэмэгдэл	556,641,543.58	772,058,475.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,188,000.00	33,881,150.00
210104	Урамшуулал	9,821,388.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,460,402.10	40,999,400.00
210201	Тэтгэврийн даатгал	347,958.66	-
210202	Тэтгэмжийн даатгал	40,936.97	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,749.58	-
210204	Ажилгүйдлийн даатгал	8,187.39	-
210205	Эрүүл мэндийн даатгал	30,030,569.50	40,999,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,040,940.24	78,115,348.23
210301	Гэрэл, цахилгаан	13,708,777.90	25,364,233.08
210302	Түлш, халаалт	34,563,397.44	43,442,948.15
210303	Цэвэр, бохир ус	8,768,764.90	9,308,167.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,085,598.32	73,980,611.70
210401	Бичиг хэрэг	14,044,300.00	3,354,800.00
210402	Тээвэр, шатахуун	53,528,800.00	60,952,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,003,023.32	5,731,359.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	515,000.00	460,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,994,475.00	3,481,500.00
2105	Нормативт зардал	5,384,500.00	3,979,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	742,800.00	680,000.00
210502	Хоол, хүнс	4,641,700.00	2,309,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	990,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,977,200.00	11,629,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	145,700.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	-

210604	Урсгал засвар	18,591,500.00	11,629,240.00
2107	Томилолт, зочны зардал	6,354,300.00	4,480,100.00
210702	Дотоод албан томилолт	6,354,300.00	4,480,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,689,500.00	5,823,757.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,060,000.00	781,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,054,300.00	586,099.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	323,800.00	297,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,000,000.00
210807	Газрын төлбөр	251,400.00	159,658.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,254,450.00	150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,238,250.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,016,200.00	150,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,525,620.34	293,303,543.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,421,200.00	288,587,796.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,833,300.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	66,899,514.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	164,318,282.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,587,900.00	57,370,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,104,420.34	4,715,747.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,104,420.34	4,715,680.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	66.92
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	33,518,783.00	62,555,709.44
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,594,300.00	11,159,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,594,300.00	11,159,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,594,300.00	11,159,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,594,300.00	11,159,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(14,594,300.00)	(11,159,800.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	18,924,483.00	51,395,909.44
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	18,924,483.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,924,483.00	70,320,392.44

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	155,208,356.39	1,346,442,328.32
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,493,786.83)	(64,493,786.83)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	90,714,569.56	1,281,948,541.49
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	90,714,569.56	1,281,948,541.49
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,615,800.00	1,615,800.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	595,746,480.28	595,487,491.65	92,330,369.56	1,283,564,341.49
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,600,000.00	-	-	13,600,000.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,864,559.43)	(10,864,559.43)
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	609,346,480.28	595,487,491.65	81,465,810.13	1,286,299,782.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,671,226,900.00	2,668,472,719.85	2,754,180.15	99.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,671,226,900.00	2,668,472,719.85	2,754,180.15	99.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,386,608,900.00	2,385,054,923.85	1,553,976.15	99.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,156,677,300.00	2,156,677,300.00	-	100.00
210101	Үндсэн цалин	1,399,635,700.00	1,350,737,674.82	48,898,025.18	96.51
210102	Нэмэгдэл	726,241,600.00	772,058,475.18	(45,816,875.18)	106.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,800,000.00	33,881,150.00	(3,081,150.00)	110.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,999,400.00	40,999,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	40,999,400.00	40,999,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,365,400.00	77,336,315.15	29,084.85	99.96
210301	Гэрэл, цахилгаан	24,585,200.00	24,585,200.00	-	100.00
210302	Түлш, халаалт	43,450,300.00	43,442,948.15	7,351.85	99.98
210303	Цэвэр, бохир ус	9,329,900.00	9,308,167.00	21,733.00	99.77
2104	Хангамж, бараа материалын зардал	73,992,900.00	73,980,611.70	12,288.30	99.98
210401	Бичиг хэрэг	3,354,800.00	3,354,800.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	60,953,000.00	60,952,952.00	48.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,739,600.00	5,731,359.70	8,240.30	99.86
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	463,600.00	460,000.00	3,600.00	99.22
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,481,900.00	3,481,500.00	400.00	99.99
2105	Нормативт зардал	4,280,000.00	3,979,000.00	301,000.00	92.97
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	680,000.00	680,000.00	-	100.00
210502	Хоол, хүнс	2,600,000.00	2,309,000.00	291,000.00	88.81
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,636,000.00	21,628,440.00	7,560.00	99.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,999,200.00	800.00	99.99
210604	Урсгал засвар	11,636,000.00	11,629,240.00	6,760.00	99.94
2107	Томилолт, зочны зардал	4,484,300.00	4,480,100.00	4,200.00	99.91
210702	Дотоод албан томилолт	4,484,300.00	4,480,100.00	4,200.00	99.91
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,023,600.00	5,823,757.00	1,199,843.00	82.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,980,000.00	781,000.00	1,199,000.00	39.44

210804	Тээврийн хэрэгслийн татвар	586,600.00	586,099.00	501.00	99.91
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	297,000.00	297,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	160,000.00	159,658.00	342.00	99.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,000.00	150,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00	150,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	284,618,000.00	283,417,796.00	1,200,204.00	99.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	284,618,000.00	283,417,796.00	1,200,204.00	99.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,899,600.00	66,899,514.00	86.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	164,318,400.00	164,318,282.00	118.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,400,000.00	52,200,000.00	1,200,000.00	97.75
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,671,226,900.00	2,668,472,719.85	2,754,180.15	99.90
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,666,891,900.00	2,662,176,219.85	4,715,680.15	99.82
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,666,891,900.00	2,662,176,219.85	4,715,680.15	99.82
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,335,000.00	6,296,500.00	(1,961,500.00)	145.25
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,335,000.00	6,296,500.00	(1,961,500.00)	145.25
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	193.00	193.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96.00	96.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	93.00	93.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	96.00	96.00	-	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	94.00	94.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,939,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,939,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,939,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		779,033.08
210301	Гэрэл, цахилгаан		779,033.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,160,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,160,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		66.92
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		66.92
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		66.92
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,939,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,939,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,939,700.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын Цагдаагийн хэлтэс /цаашид Мандал сумын Цагдаагийн хэлтэс гэх/ нь “Нийтийн хэв журмыг сахиулан хамгаалах, удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг үр чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх,
- Нийтийн хэв журам хамгаалах,
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:


- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- ЦЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/340 дүгээр тушаалаар цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд ЦЕГ-ын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар хяналт тавьж ажилладаг бөгөөд Цагдаагийн байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны 02 дугаар сард төлөвлөгөөт иж бүрэн шалгалт хийж, санхүү, үйл ажиллагааны чиглэлээр 7

үүргийн хэрэгжилтийг хангаж, тооцож ажиллахыг даалгасны дагуу Мандал сумын Цагдаагийн хэлтсээс биелэлтийг гаргаж хугацаандаа тайлагнасан байна.

Тус газраас төлөвлөгөөт иж бүрэн шалгалт хийсэн дүнд үндэслэн гүйцэтгэлийн шалгалтыг 2024 оны 02 дугаар сард хийж, өгсөн үүргийн биелэлт, үр дүн "Сайн" үнэлгээтэй хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.



Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦЕГ-ын даргын 2013 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 422 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсон байна.

Иймд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,935.0 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,924.5	70,320.4	51,395.9
Авлага	-	-	-
Бараа материал	96,027.5	128,205.7	32,178.1
Үндсэн хөрөнгө	1,167,412.8	1,087,773.7	(79,639.0)
Нийт хөрөнгө	1,282,364.8	1,286,299.8	3,935.0
Өр төлбөр	416.2	-	(416.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,281,948.5	1,286,299.8	4,351.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,282,364.8	1,286,299.8	3,935.0

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.
Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 70,320.4 мянган төгрөг болж 51,395.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ЦЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу цалингийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлаас нийт 56,565.9 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130412508 тоот дансанд төвлөрүүлсэн,
- Бараа материалын дансны үлдэгдэл 128,205.7 мянган төгрөг болж 32,178.1 мянган төгрөгөөр өссөн нь ЦЕГ-аас 17,250.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал шилжүүлэн авсан, тайлант онд 15,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч нөөцөлсөн,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,087,773.7 мянган төгрөг болж, 79,639.0 мянган төгрөгөөр буурсан нь Түнхэл тосгоны цагдаагийн хэсгийн газрыг 13,600.0 мянган төгрөгөөр үнэлэн бүртгэлд тусгасан, ЦЕГ-аас 8,910.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Мандал сумын ГХУСЗ-өөс 24,184.0 мянган төгрөгийн хурд хэмжигч, таблет, аймгийн ЗДНХ-ийн зардлаас 2,399.7 мянган төгрөгийн суурин компьютер зэргийг хүлээн авсан, бараа материалын данснаас 992.0 мянган төгрөгийн машины станцыг шилжүүлэн бүртгэсэн, болон 140,884.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,704,145.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны

орлогоос 5,000.0 мянган төгрөг, нийт 2,709,145.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 524,902.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, хангамж, бараа материалын зардлыг 141,821.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 855,820.7 мянган төгрөгөөр бууруулсан зэргээр нийт дүнгээр 553,422.9 мянган төгрөгөөр бууруулж, 2,155,722.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд хийгдсэн төсвийн тодотгол, зохицуулалтаар цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 191,751.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31,105.1 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 281,158.0 мянган төгрөг зэргээр батлагдсан төсвийг нийт 515,504.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,671,226.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,671,226.9** мянган төгрөгийн төсөв баталж, үйл ажиллагааны орлогоос 4,335.0 мянган төгрөг, улсын төсвөөс 2,666,891.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлогоос 6,296.5 мянган төгрөг, улсын төсвөөс 2,666,891.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,668,472.7** мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь “Цагдаа” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 2,709.1 мянган төгрөгөөр, “Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах” хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 45.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	Цагдаа	2,518,979.2	2,516,270.1	-2,709.1	99.9
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,233,162.2	2,232,852.3	-309.9	100.0
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	284,618.0	283,417.8	-1,200.2	99.6
3	Байцаан шийтгэх ажиллагаа	1,199.0		-1,199.0	0.0
Б	Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	152,247.7	152,202.6	-45.1	100.0
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	152,247.7	152,202.6	-45.1	100.0
	Дүн	2,671,226.9	2,668,472.7	-2,754.2	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130412403 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 1,939.7 мянган төгрөгийг хүлээн авч, 779.0 мянган төгрөгийг цахилгааны төлбөрт шилжүүлж, 1,160.7 мянган төгрөгөөр өнгөт принтер худалдан авч зориулалтын дагуу зарцуулсан байна.



Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд Мандал сумын цагдаагийн хэлтэст Шатахуун худалдан авах-СЭАМСЦХ/202303001 дугаартай, 55,781.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг */Тендер шалгаруулалтын онцгой журам, Харьцуулалтын арга/* 2023 оны 05 дугаар сарын 25, 06 дугаар сарын 07-ны өдөр зарласан боловч санал ирүүлсэн оролцогч байхгүй тул НИК ХХК-тай шатахуун худалдан авах гэрээ байгуулж, 60,952.9 мянган төгрөгийн худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46/2-170 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,781,128.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,811.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 2,741,087.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 27,410.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж үүрэг, ажлын чиглэл өгсний дагуу 15,000.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцэхгүй байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сумын Цагдаагийн хэлтсийн мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,814.0 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	5,957.5	4	5,957.5	100
Зөвлөмж	2	8,856.5	2	8,856.5	100
Нийт дүн	6	14,814.0	6	14,814.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Мандал сумын Цагдаагийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд: ЦЕГ-ын даргын 2023 оны 2/352, Санхүү, ар талын албаны даргын 2023 оны 16/2918 дугаар албан бичгүүдээр “Төсвийн зардлын үлдэгдлээр байгууллагынхаа хэрэгцээнд шаардлагатай материалыг худалдан авах болон “Ахмадын сан”-д шилжүүлж, төсвийг бүрэн зарцуулах ажлыг зохион байгуулах” гэж үүрэг, чиглэл өгсний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- Тээвэр, шатахууны зардлын хэмнэлт **15,000.0** мянган төгрөгөөр хэрэгцээнээс илүү шатахуун худалдан авч, нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

- Цалингийн хэмнэлт **56,565.9** мянган төгрөгийг “Ахмадын сан”-ийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дээрх хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор ахмадын санд төвлөрүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгуулж батлуулсны үндсэн дээр санхүүжүүлэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн **6,957.7** мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн зардлыг бодитоор төлөвлөөгүйгээс ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал хүрэлцэхгүйд хүрч, цалингийн зардлаас **6,975.7** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”: 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитоор төлөвлөж, хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй				
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

4317143998
МНОА0005 9055436
Зөвлөмж

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн	1	6,957.7					1	6,957.7				
Дүн	1	6,957.7					1	6,957.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг мэдээлээгүй.	1	-			1	-	
Дүн	1	-			1	-	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн	1	-			1	-	

